

АУДИТ ХИЙГДЭХ НЭГЖ: Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар

ДОТООД АУДИТЫН НЭГЖ:

Дундговь аймгийн Санхүүгийн
хяналт, аудитын алба

- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

АУДИТЫН НЭР: Дотоод аудитаар 2017 он, 2018 оны 1-р улирлын
санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх

Огноо: 2018 он

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: Дундговь аймгийн Орон нутгийн
өмчийн газар

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: Дундговь аймгийн Орон нутгийн
өмчийн газар

АУДИТЫН ТӨРӨЛ: Дотоод аудит

АУДИТЫН ХУГАЦАА: 2018.05.09-2018.05.15

Дотоод аудитын нэгжийн дарга:

Г. Зоригт

Багийн ахлагч

Санхүүгийн хяналт шалгалтын

Г. Эрдэнэбаатар

улсын ахлах байцаагч

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч

С. Бархасмаа

АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1 Илэрсэн асуудлууд

3.2 Дүгнэлт

3.3 Зөвлөмж

4. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Нэг. ТАНИЛЦУУЛГА

Аймгийн засаг даргын Дотоод аудитын хорооноос батлагдсан санхүүгийн хяналт, шалгалтын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2018 оны 05 дугаар сарын 08 өдрийн №08 тоот албаны даргын удирдамжийн дагуу Орон нутгийн өмчийн газрын 2017 он, 2018 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн эх үүсвэр болон түүний захиран зарцуулалтанд дотоод аудитыг хийж гүйцэтгэн тайланг танилцуулж байна.

Орон нутгийн өмчийн газрын 2017 он, 2018 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, хэрэгжилтэнд Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнийг даган гарсан холбогдох заавар, журмуудын хэрэгжилт, батлагдсан төсөвтэй хэрхэн уялдаж байгааг судлан, тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгөх зорилгоор Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч С.Бархасмаа аудитыг хийсэн болно.

Дотоод аудит хийх бэлтгэл ажлын хүрээнд Орон нутгийн өмчийн газрын 2017 он, 2018 оны 1-р улирлын төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үндсэн үйл ажиллагааны төсвийн орлогын бүрдүүлэлт төвлөрүүлэлтэд аудитын хөтөлбөрийг боловсруулан эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулахад тухайн байгууллагын дотоод хяналт хэрхэн ажиллаж байгааг тодорхойлон түүнээсээ аудит хийх горимуудаа сонгон ажилласан.

Ирүүлсэн мэдээллийн дагуу холбогдох баримтуудад хяналт, шалгалтыг зохион байгуулан Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль холбогдох журмуудтай хэрхэн нийцэж байгаа байдалтай танилцаж тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах чиглэлээр зөвлөмжийг өгч ажиллалаа.

Түүнчилэн дотоод аудит хийх явцад гарч ирсэн нотлох баримтад тулгуурлан эрсдэлийг тодорхойлж, зөвлөмжид тусгасан.

Хоёр. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Аймгийн засаг даргын Дотоод аудитын хорооноос батлагдсан санхүүгийн хяналт, шалгалтын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2018 оны 05 дугаар сарын 08 өдрийн №08 тоот албаны даргын удирдамжийн дагуу Орон нутгийн өмчийн газрын Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд түүнийг даган гарсан холбогдох заавар, дүрэм, журмуудын хүрээнд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх, санхүүгийн үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

2.2 Аудитын цар хүрээ

Орон нутгийн өмчийн газрын дотоод аудитыг гүйцэтгэхдээ Улсын секторын дотоод аудитын гарын авлага, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд, практик зөвлөмж, практик заавруудыг ашиглан удирдамжинд батлагдсан дараах цар хүрээнд хамрагдаж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, хамтын гэрээ, үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоол, заавар журам, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журам, зааврын хэрэгжилт
2. 2017 оны төсвийн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын байдал.

3. Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын баримтын бүрдүүлэлт, хууль эрх зүйн үндэслэл, зарцуулалт, үр дүн тайлан гаргалт
4. Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн зориулалт, зарцуулалт, тэдгээрийг НББ-д тусгасан байдал, баримтын бүрдүүлэлт
5. Өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалт
6. Иргэн аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал
7. Байгууллагын орон тоо, бүтэц зохион байгуулалт, ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоолт, олголтын байдал, баримтын бүрдэлт, зарцуулалт
8. Өмч хөрөнгийн бүртгэл, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тооллого, тооцоо бодолт.
9. Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх.
10. Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" - ын дагуу цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг үндсэн баримт материалтай нь тулган шалгах
11. "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын хэрэгжилт;
12. Байгууллагын 2018 оны эхний 3 сарын санхүүгийн баримтанд явцын шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

Ирүүлсэн мэдээллийн дагуу холбогдох баримтуудад хяналт, шалгалтыг зохион байгуулан Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль холбогдох заавар, дүрэм, журмуудтай хэрхэн нийцэж байгаа байдалтай танилцаж тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулахад чиглэгдсэн.

Гурав. АУДИТЫН ҮР ДҮН

Асуудал 1. Орон нутгийн өмчийн газрын төсөв, зарцуулалтын үйл ажиллагаатай танилцах;

Шалгуур:

1. Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдлөг болох.
2. "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Төрийн албаны тухай" хуулиуд болон тухайн байгууллагын салбарын хэмжээнд түүнтэй холбогдон гарсан хууль, дүрэм, заавар, журмуудын заалтыг хэрэгжүүлсэн байх.

Бодит нөхцөл байдал:

Орон нутгийн өмчийн газар нь "Орон нутгийн өмчийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулж, өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх, бүртгэл тооцоог байгууллага бүрээр хөтлөн өмчийн үр ашгийг дээшлүүлэх" гэсэн эрхэм зорилготойгоор ажилласан байна. Тус зорилгын хүрээнд:

1. Орон нутгийн өмчийн байгууллагуудад өмчийн харилцааны хууль, эрх зүйн баримт бичгүүдийг чанд мөрдүүлэх, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх
2. Өмчийн эзэд болон өмч хамгаалах зөвлөлүүдийг чадавхижуулж, өмчид тавих хараа хяналтыг сайжруулах
3. Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах гэсэн зорилтуудыг тодорхойлсон байна.

Шалгалтанд хамрагдсан 2017 оны санхүүгийн баримтанд нэгдүгээр гарын үсгийг байгууллагын дарга С.Ууганбаяр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч О.Шинэжаргал, Ц.Даваа нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

Орон нутгийн өмчийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан нь "Саруул баян уул-Аудит" ХХК-аар аудитлагдаж зөрчилгүй дүгнэлт авсан байна.

2017 оны санхүүгийн тайлангаар: Тус байгууллага нь тайлант хугацаанд 81,089.7 мянган төгрөгийн төлөвлөгөөт санхүүжилтыг орон нутгийн төсвөөс туслах үйл ажиллагаанаас 7,750.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн авч байгууллагын 100080051006 тоот дансаар дамжуулан төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу зарцуулсан, төсвийн хэмнэлтээсээ 74.8 мянган төгрөгийн ахмадын сандаа шилжүүлсэн харилцах дансны үлдэгдэлгүй, өглөггүй, 182.2 мянган төгрөгийн авлагатайгаар тайлагнасан байна. Өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн 100080051424 тоот дансанд төсвийн урамшуулал болох 429.1 мянган төгрөгийн орлого авч байгууллагын ажилчдад нийгмийн асуудлыг дэмжихэд зориулж, мөнгөн хэлбэрээр нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд зарцуулсан байна.

Ахмадын сангийн 100080051503 тоот дансны харилцахын эхний үлдэгдэл 569.5 мянган төгрөг, хэмнэгдсэн төсвөөс 74.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, үйл ажиллагааны зардалд 300.0 мянган төгрөгийг зарцуулж, ахмадын сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 344.3 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд "Тогтвортой-Амьжиргаа-2" төслөөс Samsung ML1660 принтерийг 100.0 мянган төгрөгөөр шилжүүлэн авсан, телефон аппарат 1 ширхэгийг 144.9 мянган төгрөгөөр, компьютерийн гар 1 ширхэгийг 34.9 мянган төгрөгөөр дрилл 1 ширхэгийг 120.0 мянган төгрөгөөр нийт 299.8 мянган төгрөгөөр худалдан авч нийт 399.8 мянган төгрөгийн хөрөнгө дансанд орлогдож бүртгэсэн. Тавилга эд хогшил дансанд 500.0 мянган төгрөгөөр албаны сандал 1 ширхэгийг худалдан авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хуулийн дагуу жилд 2 удаа зохион байгуулж, тооллогын бүртгэл хөтлөн баталгаажуулан ажиллажээ.

Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 1,899.6 мянган төгрөг өөрийн хөрөнгөөр 10,107.8 мянган төгрөгийн бараа, материал худалдан авч, албан хэрэгцээнд зарцуулсан бараа материалын үнэ 8,978.4 мянган төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 3,029.0 төгрөгөөр тайлагнагджээ.

Урсгал засварын зардлаас сэлбэг худалдан авахад 3,660.0 мянган төгрөг, барилгын засварын материал авахад 904.9 мянган төгрөг зарцуулсан байна. Урсгал засварын зардлаас 300.0 мянган төгрөгөөр авто машины суудлын бүрээс худалдан авч зарцуулсан зөрчил илэрсэн нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалыг зөрчсөн байна.

Авто машины дансанд бүртгэлтэй 0044ДУЭ улсын дугаартай LEXUS470 машинд хувийн хэрэг хөтлөгдөөгүй, урсгал зардлын хийгдсэн тухай бүртгэл тусгагдаагүй зөрчил байна.

Эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд нь хийж эд хариуцагчийн тооцоог бодон "Бараа материалын тооцоо бодсон баримт"-ыг бичиж удирдлагаар хянуулан тамга тэмдэг дарж баталгаажуулан ажилласан байна.

Дүгнэлт: Санхүүгийн тайлангаа хагас бүтэн жилээр хуулийн хугацаанд нь гаргаж хэвшсэний зэрэгцээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэлээ санхүүгийн программаар хөтөлж журналын бичилтүүд үнэн зөв хийгдсэн байна.

Зөвлөмж:

1. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулан ажлын төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэх, хяналт тавих
2. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалыг мөрдөж ажиллах.

Асуудал 2 . Орон нутгийн өмчийн газрын орон тоо, бүтэц зохион байгуулалт, ажиллагсадын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал, баримтын бүрдэлт, зарцуулалт.

Шалгуур: Хууль, тогтоомж, журам, зааврын хэрэгжилт хангагдсан байх

Бодит нөхцөл байдал:

Орон нутгийн өмчийн газар нь бүтэц зохион байгуулалт орон тооны хувьд төлөвлөгөөгөөр 7, тайлант онд удирдах 1, гүйцэтгэх 6, нийт 7 орон тоотойгоор ажиллаж ирсэн нь төлөвлөгөөт орон тоонд багтаан ажилласан байна.

Газрын даргын тушаалаар 2017 оны 06 сарын 02-ны өдрийн Б/17 тоот тушаалаар худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Э.Мядагмааг чөлөөлсөн боловч 2017 оны 09 сарын 04-ны өдрийн 139/ШШ2017/00319 дугаарт Аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр уг ажилд нь буцаан томилох, ажилгүй байсан хугацааны олговор 1445571 /нэг сая дөрвөн зуун дөчин таван мянга таван зуун далан нэг/ төгрөгийг гаргуулан олгохоор шийдвэрлэгдсэнийг 2017 оны 09 сарын 29-ны өдөр буцаан томилж олговор болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн байгууллагын төсвөөс төлж хохирлыг барагдуулсан байна. Мөн газрын даргын тушаалаар Э.Мядагмааг өөрийн хүсэлтээр нь 2017 оны 11 дугаар сарын 08-ны өдрөөр дахин чөлөөлсөн байна. Ажлаас чөлөөлөхдөө нэг сарын цалингийн хэмжээтэй тэнцэх хэмжээний тэтгэмж гэх 236857/хоёр зуун гучин зургаан мянга найман зуун тавин долоо/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас олгосон байна. Энэ нь тухайн сарын цалин олговортой давхардаж олгогдсон мөн Төрийн албаны тухай хуулийн /30.1.Энэ хуулийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, мөн хуулийн 23.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тусламж олгож болно.30.2.Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно/ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Дүгнэлт:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг мөрдөн цалингийн сандаа багтаан ажилласан байна. Ажилтаныг үндэслэл буруу шийдвэрээр ажлаас чөлөөлсөн, нөхөн олговрыг байгууллагын төсвөөс барагдуулсан, хуулийн үндэслэлгүй тэтгэмж олгосон байна.

Зөвлөмж:

Улсын Их Хурлын 2017 оны 04 сарын 04-ны 29-р тогтоол /29.4 төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх, 29.5 төрийн албан

хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах/-ын заалтуудыг баримтлан ажиллах.

Асуудал: 3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай танилцах

Шалгуур: 3 Эрх зүйн хүрээнд хэрэгжсэн байх.

Бодит нөхцөл байдал:

Хуулийн дагуу дараах мэдээллүүдийг байршуулж цахим хуудсыг нээж ажилласан байна. Үүнд:

1. Байгууллагын үндсэн мэдээлэл /дарга, нягтлан бодогч нарын овог нэр, албан тушаал, гар утас, цахим хаяг/-ыг байршуулсан боловч байгууллагын нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй.

2. 2017 оны төсвийн хуваарь, орлогын төлөвлөгөөг оны эхэнд байршуулж, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг байршуулсан боловч хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бичээгүй.

3. Эхний хагас болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт байршуулсан.

4. Байгууллагын санхүүгийн ил тод байдлын самбарт төсөв, сар бүрийн мэдээ тайланг шинэчлэн байршуулж, цахим хуудсаар мэдээлж шилэн дансны хуулийг хэрэгжүүлж байна.

Дүгнэлт: Шилэн дансны хуулийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийг цахим хуудсанд хугацаанд байршуулсан байна.

Зөвлөмж:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 тоот тушаалаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг хэрэгжүүлж ажиллах.

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй байгууллагад "Мэдээлэл оруулах хэрэглэгчийн эрх", "Байгууллагын админ эрх" гэсэн 2 эрх олгогдсон тул эдгээр админ эрхүүдийг ашиглаж хэвших, / байгууллагын админ эрхээрээ байршуулсан мэдээллээ шалгаад дээд байгууллагадаа илгээж байх /.

3. Мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх гэсэн зарчмуудыг мөрдөж ажиллах

3.2. Нэгдсэн Дүгнэлт:


Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу төсвийг үр ашигтай зарцуулах, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтуудыг бүрэн гүйцэд хөтөлж, НББ-ийг ОУ-ын стандартын дагуу программаар гүйцэтгэдэг, баримтын эмх цэгц сайн, санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж хэвшсэн байна.


Зөвлөмж:


1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 тоот тушаалаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг хэрэгжүүлж ажиллах, мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллээ хугацаандаа, иж бүрэн, ойлгомжтой байдлаар байршуулан нийтэд мэдээлж ажиллах.

2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулан ажлын төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэх, хяналт тавих.

3. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалыг мөрдөж ажиллах.
4. Авто машины хувийн хэрэг хөтлөх, холбогдох бичилтүүдийг нөхөж бичих.
5. Улсын Их Хурлын 2017 оны 04 сарын 04-ны 29-р тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.
6. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, аудитын албанд бичгээр ирүүлэх.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Г.ЭРДЭНЭБААТАР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  С.БАРХАСМАА

ТАНИЛЦСАН:
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА  С.УУГАНБАЯР
НЯГТЛАН БОДОГЧ Ц.ДАВАА



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 26-05/08

Мандалговь

Төлбөр тогтоох тухай

Аймгийн засаг даргын Дотоод аудитын хорооны тогтоолоор баталсан санхүүгийн хяналт, шалгалтын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2018 оны 5 дугаар сарын 8-ний өдрийн 08 тоот албаны даргын удирдамжийн дагуу Орон нутгийн өмчийн газрын 2017 он, 2018 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн эх үүсвэр болон түүний захиран зарцуулалтанд Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Г.Эрдэнэбаатар, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч С.Бархасмаа нар шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар: Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Б/17 тоот тушаалаар худалдан авах ажиллагааны мэргэжилтэн Э.Мядагмааг чөлөөлсөн боловч 2017 оны 9 сарын 4-ний өдрийн Аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 139/ШШ2017/00319 шийдвэрээр уг ажилд нь буцаан томилох, ажилгүй байсан хугацааны олговор 1445571 (Нэг сая дөрвөн зуун дөчин таван мянга таван зуун далан нэг) төгрөгийг гаргуулан олгохоор шийдвэрлэгдсэнийг 2017 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр буцаан томилж олговор болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн байгууллагын төсвөөс төлж хохирлыг барагдуулсан байна. Мөн газрын даргын тушаалаар Э.Мядагмааг өөрийн хүсэлтээр нь 2017 оны 11 дугаар сарын 8-ны өдрөөр дахин чөлөөлсөн байна. Ажлаас чөлөөлөхдөө нэг сарын цалингийн хэмжээтэй тэнцэх хэмжээний тэтгэмж гэх 236 857 (Хоёр зуун гучин зургаан мянга найман зуун тавин долоо) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас олгосон байна. Энэ нь тухайн сарын цалин олговортой давхардаж олгогдсон ба Төрийн албаны тухай хуулийн "30.1-д Энэ хуулийн 23.1, 23.3-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тусламж олгож болно", "30.2-д Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Иймд:

"Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил,

түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ”.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтад “Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсаны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, “Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дах заалтад “энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1 “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 дахь заалтад “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” гэж заасны дагуу мэргэжилтэн Э.Мядагмаад олгосон тэтгэмж болох 236857 (Хоёр зуун гучин зургаан мянга найман зуун тавин долоо) төгрөгийг хуулийн үндэслэлгүй зориулалт бусаар зарцуулсан тул орон нутгийн орлого болгох.

2. Төсвийн орлого болгосон 236857 (Хоёр зуун гучин зургаан мянга найман зуун тавин долоо) төгрөгийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймгийн Төрийн сан банк дахь хүү, торгуулийн 100080000952 тоот дансанд оруулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаяр, нягтлан бодогч Ц.Даваа нарт хариуцуулах.

3. Актыг эс зөвшөөрвөл “Дотоод аудитын дүрэм”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэхь заалтын дагуу гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Г.ЭРДЭНЭБААТАР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ С. БАРХАСМАА

ТАНИЛЦСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ

С.УУГАНБАЯР
Ц.ДАВАА

